



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/31

Модот

Цахим системд хандах эрх бүхий
албан хаагчид томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3, 42.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус сумын Засаг даргын Тамгын газрын "Хүний нөөцийн нэгдсэн систем"-ын хүрээнд программд хандах эрхийг Засаг даргын Тамгын газрын санхүү албаны нягтлан бодогч (Б.Буяндэлгэр)-т, уг системд оруулсан мэдээ мэдээлэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн (И.Найманцэцэг) нарт тус тус эрхийг олгосугай.

2.Байгууллага болон хувь хүний нууцыг чандлан хадгалж, цаашид задруулахгүй ажиллахыг Санхүү албаны нягтлан бодогч (Б.Буяндэлгэр)-т, Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн (И.Найманцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ү.ИЧИНХОРЛОО